

АВРАГЧДЫН СУРГАЛТ БЭЛТГЭЛИЙН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

*ДХИС-ийн ОБС-ийн Гамигаас хамгаалах албаны
тэнхимийн багш, ахмад Н.Төгсбаяр*

Хураангуй: Онцгой байдлын байгууллагын хамгийн их анхаарал татаж байгаа мөн анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай асуудлын нэг бол алба хаагчдын дотоодын болон гадаадын системтэй сургалтын асуудал юм. Төрөл мэргэжлийн аврагч нарт тусгай мэргэжлийн шаталсан чиглэлийн сургалт дутмаг, албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажил үүргийн хуваарийг төдийлөн хангадаггүй, гамшиг ослын голомтод үүрэг гүйцэтгэх ур чадвар, чадамж сул байгаагаас шалтгаалан өөрсдийн амь нас, эрүүл мэндээр хохирох, тактикийн алдаа дутагдал гаргах зэрэг асуудал тулгарч байна. Иймээс төрөл мэргэжлийн аврагч нарт явагдаж байгаа сургалтын үйл ажиллагааг өргөжүүлэх, эрчимжүүлэх зэргээр сургалтын нөлөөг нэмэгдүүлэх асуудлыг хөндөж бусад улс орны сургалтын системтэй харьцуулан судлах, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг судлах зорилт тавьсан юм.

Abstract: One of the most important and urgent issues for the emergency services is the personnels, domestic and foreign systematic training. There is a lack of specialized training for rescuers does not meet the job description specified in the job description, loss of life and health due to lack of skills and abilities to act at the disaster site; There are problems such as making tactical mistakes. Therefore the type, expand training for professional rescuers; to compare the training system of other countries to increase the impact of training, such as intensification, The aim was to study whether it could be implemented.

Түлхүүр үгс: Аврагч, сургалт бэлтгэл, Онцгой байдлын байгууллага.

Key words: rescue, training, Emergency Management Agency.

Удиртгал

Сургалтын агуулга нь ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэших хэсгээс бүрдэх бөгөөд асуулга тус бүр нь дараах зорилтыг хэрэгжүүлнэ.

- Ерөнхий суурь хэсгийн агуулга нь алба хаагчдад боловсрол олгоход зайлшгүй шаардлагатай шинжлэх ухааны үндсийг эзэмшүүлэх,
- Мэргэжлийн суурь хэсгийн агуулга нь шинжлэх ухаан, технологи, нийгэм, хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр мэргэжил эзэмшихэд зайлшгүй шаардлагатай онол-арга зүйн мэдлэг эзэмшүүлэх,
- Мэргэших хэсгийн агуулга нь нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн тухайн мэргэжлээр мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэх” гэж хуульчилсан байдаг.

Сургалт гэдэг ухагдахууны талаар эрдэмтэн судлаачдын олон тодорхойлолт байдаг. Тэдгээрийг тоймлон нэгтгэн авч үзвэл:

- Сургалт бол тодорхой тогтолцоо бүхий мэдлэг, чадвар, дадал төлөвшүүлж, боловсрол олгох, дамжуулах үйл ажиллагаа, төлөвлөгдсөн үйл явц, арга хэрэгсэл, тогтолцоо юм¹¹.
- Сургалт бол чанарын өөрчлөлт хийх хэрэгсэл бас орчин юм

Сургалт бол багшийн сургах, шавийн сурч танин мэдэх үйл ажиллагааны нэгдэл, амьдрал, үйл ажиллагааны орчин үеийн шаардлагад нийцүүлэн амьдрах ухаан, нийгмийн туршлагыг ахмад үеэс хойч үедээ систем дэс дараатай, зорилго чиглэлтэйгээр зохион байгуулалттайгаар дамжуулан өвлүүлэхэд чиглэсэн зорилго, агуулга, зарчим, арга хэлбэр, хэрэгсэл гэсэн үндсэн бүтэц бүхий тасралтгүй хөгжих үйл явц юм.

• Сургалт бол бие хүнийг төлөвшүүлэх, хөгжүүлэх ажлын гол цөм нь юм. "Сургалт бол гамшгаас урьдчилан сэргийлэх иргэн бүрт хүрч ажиллах түлхүүр мөн¹²". Харин "бэлтгэл" гэдэг үгийг монгол хэлний тайлбар тольд бэлдвэр, урьдчилан бэлдсэн юм. бэлэн болгож зэхэх¹³ гэж тайлбарлажээ .

Үндсэн хэсэг

Онцгой байдлын нэр томьёо, үндсэн ухагдахуунууд:

Онцгой байдлын албаны үндсэн нэр томьёо, ойлголт ухагдахуунуудыг дараах байдлаар тодорхойлж байна.

"**гамшгийн онцгой нөхцөл байдал**" гэж аюулт үзэгдэл, ослоос үүдэн хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн байгаа орчин, дэд бүтцэд ноцтой хохирол учруулж, хүн-нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагаа алдагдахыг¹⁴;

Онцгой нөхцөл байдал гэж тодорхой нутаг дэвсгэрт осол, байгалын аюулт үзэгдэл, сүйрэл, байгалын бусад гамшгийн улмаас хүний амь нас үрэгдэх, хүмүүсийн эрүүл мэнд буюу хүрээлэн буй байгаль орчимд гэм хор учруулах, материалын үлэмж хохирол бий болох, хүмүүсийн амьдралын хэвийн үйл ажиллагаа алдагдахаар нөхцөл байдал үүсэхийг хэлнэ¹⁵.

Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гамшгаас хамгаалах төрийн бодлого, гамшгаас хамгаалах хууль тогтоомжийг

¹¹ М.Тэгшжаргал. Боловсрол судлал. УБ, 2010 он

¹² ШУ-ны доктор, профессор О.Үржин Гамшгийн удирдлагын өөрчлөлт, шинэчлэл. Илтгэл, Үндэсний бага хурал. УБ. 2001 он

¹³ Я.Цэвэл. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, УБ. 2013 он

¹⁴ Гамшгаас хамгаалах тухай хууль

¹⁵ С.Нарангэрэл "Монголын эрх зүйн англи, орос, латин хадмал эх толь бичиг", УБ. 2015 он

хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэгтэй байгууллага юм.

Онцгой нөхцөл байдал үүссэн үед гамшиг ослын голомтод аврах ажиллагааг зохион байгуулах мэргэжлийн алба хаагчдын аврагч гэнэ.

Аврагч нь (Эрэн хайх аврах ажиллагаанд бэлтгэгдсэн эрх бүхий алба хаагч)-ийг¹⁶ хэлнэ.

Онцгой байдлын байгууллагад төрөл мэргэжлийн аврагч нар нь дараах төрөлтэй байна. Үүнд

Аврагч-химичин: Албаны бэлэн байдлыг хангаж, цацраг, химийн бодис алдагдсан болон хүн, малын гоц халдварт өвчин тархсан үед тандалт явуулах, саармагжуулах, ариутгал халдваргүйжүүлэлт хийх үүрэгтэй

Аврагч-химичин нь:

1. Цацраг, химийн бодис алдагдан болон хүн, малын гоц халдварт өвчин гарсан үед тандалт явуулах, саармагжуулах, халдваргүйжүүлэлт хийх

2. Цацраг, химийн бодис алдагдсан болон хүн, малын гоц халдварт өвчин гарсан үед тандалт явуулах, саармагжуулах, халдваргүйжүүлэх дадлага, сургуульд хамрагдах, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Аврагч-тэсэлгээчин: Албаны бэлэн байдлыг хангаж, гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж, тэсэрч, дэлбэрэх бодисыг аюулгүй болгох үүрэгтэй.

Аврагч-тэсэлгээчин нь:

1. Тэсэрч дэлбэрэх бодисыг аюулгүй болгох арга хэмжээг хэрэгжүүлэх

2. Тэсрэх бодис аюулгүй болгох тусгай зориулалтын техник, багаж хэрэгслийн бэлэн байдал, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Аврагч тэсэлгээчин-нохой хөтлөгч: Төв орон нутгийн Онцгой байдлын байгууллагад албаны нохойг эрэн хайх аврах чиглэлээр сургах, албаны нохойн ур чадварыг дээшлүүлэх үүрэгтэй.

Аврагч тэсэлгээчин-нохой хөтлөгч нь:

1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хүрээнд сургалт, хүний хөгжлийн бодлого чиг үүргийг хэрэгжүүлэх.

2. Гамшгийн голомтод албаны нохой ашиглаж эрэн, хайх аврах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Аврагч-нохой хөтлөгч: Төв орон нутгийн Онцгой байдлын байгууллагад албаны нохойг эрэн хайх аврах чиглэлээр сургах, албаны нохойн ур чадварыг дээшлүүлэх үүрэгтэй

¹⁶ “Эрэн хайх аврах ажиллагаа ОББС 0001:2018” стандарт

Аврагч-нохой хөтлөгч нь:

1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хүрээнд сургалт, хүний хөгжлийн бодлого чиг үүргийг хэрэгжүүлэх.

2. Гамшгийн голомтод албаны нохой ашиглаж эрэн, хайх аврах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Аврагч-усчин: Албаны бэлтгэл, бэлэн байдлыг хангаж, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлж хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг авран хамгаалах
Аврагч-усчин нь:

1. Гамшиг ослын үед ажиллах бэлтгэл бэлэн байдлыг хангаж, төлөвлөгөөт сургалтад тасралтгүй хамрагдах

2. Аюулгүй ажиллагааг чанд сахиж ажиллах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Аврагч: Албаны бэлтгэл, бэлэн байдлыг хангаж, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлж хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг авран хамгаалах
Аврагч нь:

1. Гамшиг ослын үед ажиллах бэлтгэл бэлэн байдлыг хангаж, төлөвлөгөөт сургалтад тасралтгүй хамрагдах

2. Аюулгүй ажиллагааг чанд сахиж ажиллах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Холбоочин-аврагч: Гамшиг ослын дуудлагыг цаг алдалгүй түргэн шуурхай, үнэн зөв хүлээн авч, холбогдох албан тушаалтанд хүргэх

Холбоочин-аврагч нь:

1. Гамшиг ослын дуудлагыг хүлээн авч, гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдыг мэдээ мэдээллээр хангах

2. Холбооны техник хэрэгслийн бэлтгэл бэлэн байдлыг хангах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Аврагч жолооч-холбоочин: Албаны техникийн өдөр тутмын бэлтгэл, бэлэн байдлыг хангах, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэн хүний амь нас эрүүл мэнд, эд хөрөнгийг аврах хамгаалах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

Аврагч жолооч-холбоочин нь:

1. Эрэн хайх, аврах ажиллагаан тусгай зориулалтын автомашин, тоног төхөөрөмж багаж зэвсэглэмжийн бэлтгэл бэлэн байдлыг хангах.

2. Автомашин техникийг ажиллуулах явцад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа болон замын хөдөлгөөний хууль, дүрмийг мөрдөн ажиллах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Эмнэлгийн зааварлагч¹⁷:Гамшгийн голомтод нэрвэгдэгсэд, аврах багийн бүрэлдэхүүнд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, эмнэлгийн байгууллагад шилжүүлэх, шаардлагатай тохиолдолд зөөвөрлөх

Эмнэлгийн зааварлагч нь:

1. Иргэд багийн хамт олон гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх зааварчилгаа өгөх, сургалт зохион байгуулах

2. Нэрвэгдэгсдэд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх гэх мэт.

2012 онд ШУ-ны доктор. профессор О.Үржин. доктор. профессор П Цэдэв нар "Эрэн хайх аврах ажил" ном гаргаж түүнд төрөл бүрийн гамшгийн үед эрэн хайх аврах ажлыг гүйцэтгэх талаар авч үзсэн байна. Мөн 2017 онд Гамшгаас хамгаалах үндэс" /Мэргэжлийн анги. (тусгай чиг үүргийн томилгоот бүлгийн бүрэлдэхүүнд зориулав/ ном гаргасан. Энэ номонд гамшгаас хамгаалах эрх зүйн үндэс. аюулт үзэгдэл, ослын ойлголт, учруулах хор уршиг, хамгаалах арга хэмжээ, орон нутаг, байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөлт, үйл ажиллагааны талаар авч үзсэн байна.

Харин ХСИС-ийн магистр хурандаа С.Баттөмөр "Аврах үйл ажиллагаанд аврагчдын сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын бэлтгэл нөлөөлөх нь" Хошууч Ж.Алтанхуяг "Аврагчдын сургалтын онол арга зүй, сургалт бэлтгэлд хийсэн шинжилгээ, сургалтыг боловсронгуй болгох арга зам" сэдвээр магистрын судалгааны ажил хийжээ. Энэ судалгаа нь аврагчдын сургалт бэлтгэлийн боловсрол олгох сургалтын онол арга зүйн үндэс, онцгой байдлын алба хаах хугацаандаа мэргэжилтэй ажилтан бэлтгэх боломж, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний загварыг боловсруулсан байна.

Судлаачдын бүтээлд аврагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсронгуй болгох арга зам талаас нь голчлон судалсан бол энэхүү судалгааны ажлаар аврагчдын өнөөгийн сургалт бэлтгэл, давтан сургах хэрэгцээг нь тодорхойлж байгаараа онцлог юм.

Гадаад орны зарим туршлага

а) БНСУ-ын аврагч нарын сургалт

БНСУ-ын Онцгой байдлын албанд анх элсэн орохдоо элсэхийг хүсэгч нь тухайн мэргэжлийн чиглэлээр дипломын болон түүнээс дээш зэрэгтэй байна гэсэн шаардлага тавьдаг байна¹⁸ . Мөн тус шаардлагыг хангасан иргэдээс төрийн жинхэнэ албаны шалгалт гэж авдаг ба төрийн жинхэнэ албаны шалгалт нь 9 дүгээр зэргийн төрийн жинхэнэ албан хаагч гэсэн шатлалаас /ихээс бага руу/ 1 дүгээр зэргийн төрийн жинхэнэ албан хаагч гэсэн зэрэгтэй байдаг.

¹⁷ ОБЕГ-ын даргын 2019 оны А/239 тушаал

¹⁸ Fire-related laws of korea 2016.x.187

Онцгой байдлын албанд гал сөнөөгч, аврагчаар орохын тулд 9 зэргийн жинхэнэ албан хаагчийн шалгалтад тэнцсэн байх ёстой байдаг байна

Мөн анх аврагч, гал сөнөөгч албан тушаалд томилогдсон алба хаагч эхний 6-8 сар тухайн мэргэжлээр 10 дээш жил ажилласан албан хаагчийн удирдлагын доор зөвхөн дадлагажигчаар ажиллуулдаг ба үндсэн цалингийн 80 хувьтай тэнцэх хэмжээний цалин авдаг байна. Энэ нь илүү дадлага туршлагатай болгох зорилготой юм. Өөрөөр хэлбэл хүний амь насыг аврах, гал, устай тэмцэх амаргүй ажлыг өндөр хариуцлагын дор гүйцэтгэх ёстойг энд харуулж байна.

Аврагч, гал сөнөөгч нар анх томилогдсон албан тушаалдаа 1 жил ажилласны дараа албан тушаал ахих, өөр орон нутаг руу шилжих боломжтой болдог байна. Ингэхдээ албан тушаал ахихын тулд тухайн албан тушаалын зэрэглэлийн дагуу тогтоосон тусгай шалгалт байдаг ба тус шалгалтад заавал тэнцсэн байх шаардлага тавьдаг. Тус шалгалт нь онолын, ур чадварын гэсэн 2 үе шаттай явагддаг байна. Эндээс үзвэл, аврагч, гал сөнөөгч нар нь нэг албан тушаалдаа байнга ажиллах бус мэдлэгтэй, ур чадвартай бол албан тушаал дэвших бүрэн боломжтой нь харагдаж байна.

Мөн бүсүүдэд албан хаагч нарын мэргэжил дээшлүүлэх төв гэж байдаг ба тус төвд тусгай хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдаж дипломын мэргэжилтэй албан хаагч бакалаврын зэрэгтэй болж болдог.

БНСУ-д аврагчдад мэргэжлийн зэрэг олгодог ба 1, 2, 3 гэсэн мэргэшлийн зэргээс шалтгаалж цалингийн нэмэгдэл авдаг байна. Тухайлбал БНСУ-ын ерөнхийлөгчийн баталсан хэд хэдэн түвшний сургалтын гэрчилгээ /сертификат/ байдаг байна. Үүнд:

- Эмнэлгийн анхны тусламжийн 1,2 дугаар зэрэг
- Галын аюулгүй байдал хариуцагч 1, 2, 3 дугаар зэрэг
- Галын тоног төхөөрөмжийн инженерийн 1, 2 дугаар зэрэг /Fire Mechanical Professional Engineers/
- Галын дохиоллын инженерийн 1, 2 дугаар зэрэг /Fire Mechanical Professional Engineers/
- Барилгын галын аюулгүй байдлын инженерийн 1, 2 дугаар зэрэг/ Fire Mechanical Professional Engineers//

Дээрх гэрчилгээг албан хаагч нар өөрсдөө бэлдэж онолын мэдлэг, биеэр хийж гүйцэтгэх /ур чадвар/ гэсэн 2 төрлөөр өгч тэнцсэн тохиолдолд гэрчилгээ авдаг ба тэнцсэн албан хаагч нар цалингийн нэмэгдэл авах, тэтгэвэрт гарсны дараа бусад аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах бүрэн боломжтой болдог байна. Энэ нь өөрийн мэргэжлийн мэдлэг чадвараа нэмэгдүүлэх бас нэг боломж болж байгаа юм.

Аврагч нар 15 удаа өдрийн ээлж, 15 удаа шөнийн ээлж гэсэн тогтолцоогоор ажилладаг ба 7 хоногт 2 удаа онолын хичээлд 2 удаа дадлагын хичээлд заавал хамрагддаг байна. Мөн тус улсын их дээд сургуулиудад хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын хөтөлбөрийн дагуу аврагч нар жилд 5-12 кредитийн хичээл судалдаг төлөвлөгөөтэй байдаг бол тухайн аврагч 40 кредит судалсан тохиолдолд мэргэжлийн дагуу их дээд сургуулиудын 3 дугаар курсээс үргэлжлүүлэн суралцах боломжтой болдог байна.

АНУ-ын аврагч нарын сургалт

(Кансас мужын их сургуулийн гал сөнөөгч болон аврагчийн сургалтын жишээн дээр)

АНУ Кансас мужын гал сөнөөх анхан шатны сургалт¹⁹

Институтын гал сөнөөх сургалт нь үндсэн гал сөнөөгчийн сургалтын хөтөлбөрөөс гадна галын багаж хэрэгслийн ашиглалт, хэрэглээ болон жолооч, оператор зэрэг түвшний өргөн хүрээг хамардаг. Гал сөнөөгчийн 1 болон 2 дугаар түвшний сургалтын сэдвүүдийн зорилго нь Гал сөнөөгчийн үндсэн сургалтуудаас гадна гал унтраах ангийн хэрэгцээ шаардлагаас үүдэн агаарын тээврийн ослын үед аврах гал сөнөөх, ус шахагч төхөөрөмжтэй ажиллах, бусад багаж тоног төхөөрөмжтэй ажиллах түүнчлэн операторын, жолоочийн гэсэн сургалтуудад чиглэнэ. Хөтөлбөрийн энэ түвшин нь аврагч, гал сөнөөгчийн үйл ажиллагааны бүхий л үе шатыг агуулсан байдаг. Үүнд :

- Гал сөнөөгчийн үндсэн сургалт
- Эрэн хайх болон аврах ажиллагааны үндсэн техник
- Жолооч/оператор: Агаарын тээврийн аврах ажиллагаа
- Жолооч/оператор: Агаарын тээврийн аврах болон гал сөнөөх ажиллагаа
- Жолооч/оператор: Ус шахагч төхөөрөмж
- Жолооч/оператор: ус шахагч/агаарын тээврийн
- Онцгой байдлын үе дэх түргэн тусламжийн жолооч бэлтгэх сургалтын хөтөлбөр
- Этанол: хариу арга хэмжээ авах
- Гал сөнөөгч I
- Гал сөнөөгч II
- Гал сөнөөгчийн ур чадварын сургалт
- Онцгой байдлын үед пропаныг тээвэрлэх-сургалтын танхим, лабораторид
- Аюултай хэрэглэгдэхүүнүүдийн тухай ойлголт
- Аюултай материалуудын ашиглалт

Галын зааварлагчийн сургалт болон хөгжил

¹⁹ Burmaa N 2016 conference bookiet 8 shajing the future- organizational development in public administration

Гал түймэртэй тэмцэх газрын ажилтнуудад үндэсний гал түймэртэй тэмцэх байгууллагын гэрчилгээ авахын тулд галын зааварлагч болон гал сөнөөгч гэсэн ангиудад элсэлт авч сургалт явуулдаг байна.

Мэргэжлийн ур чадвар өндөртэй галын зааварлагч, үндэсний галын аюулгүй байдлын ассоциацийн 1041 стандартын дагуу хөтөлбөр боловсруулж сургалт зохион байгуулна. Энэ сургалтын хөтөлбөр нь галын зааварлагч, гал сөнөөгчийг хувь хүний хөгжил болон мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэхэд түлхэц болдог байна.

Сургалтын 2-р хэсэг нь семинар, дадлага бөгөөд 16 орчим цаг үргэлжилнэ, семинарыг нүүр тулсан ярилцлага маягаар явуулах ба суралцагчдыг бодит байдалтай танилцуулахад илүү анхаарч дадлагаар онолыг бататгадаг байна.

Семинар: Энэ семинарыг АНУ-ын олонхи мужуудад гал сөнөөгч болон галын зааварлагч бэлтгэх сургалтын хөтөлбөртөө тусгасан байдаг. Гал сөнөөгч болон аврагчийн институт нь энэхүү сургалтыг явуулахад шаардагдах бүхий л багаж тоног төхөөрөмжөөр хангасан төдийгүй багш боловсон хүчний асуудлыг ч мөн шийджээ. Галын зааварлагч гэсэн статус нь зааварлагч багшийн өөрийн мэргэжлийн ур чадвартай нягт уялдаа холбоотой байдаг ба мөн түүнчлэн цагийн багш нь институтын бусад багш нартай ижил эрхтэй, адил үүрэг хүлээдэг. Институтээс гаргасан журамд дээрх галын зааварлагчийн гэсэн статус маш чухал ач холбогдолтой.

Гал сөнөөгчийн сургалт семинар

Энэ хөтөлбөрийн хамгийн чухал гол анхаарах сэдэв бол жил тутамд явагддаг галын сургуулиас зохион байгуулдаг семинар юм. Кансас даяар бүс нутгийн семинарт нэг өдрийг зориулан галын аюулгүй байдал түүнээс сэргийлэх болон хор уршгийн талаар сургалт зохион байгуулдаг. Илтгэгчид нь үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн илтгэгчид байдаг бөгөөд өөрсдийн илтгэлээ семинар хэлбэрээр хүргэдэг. Энэ нь маш их үр өгөөжтэй семинар болдог бөгөөд жилд 500 орчим аврагч, гал сөнөөгчид тус сургалтанд хамрагддаг. Энэхүү 1 удаагийн хөтөлбөрт сонсогчид давамгайлан оролцдог ба аврах гал унтраах ангиудаар дамжуулан сургалт дадлага хослуулан явуулдаг. Кансас мужийн институт нь тус сургалтандаа маш олон тооны гал сөнөөгч, аврах албаны байгууллагуудтай хамтран ажилладаг.

Аврагчдын техникийн сургалт

Аврагчийн техникийн хөтөлбөрт мэргэжлийн ур чадвар нь NFPA 1006 (National Fire Protection Association) стандартаар баталгаажсан байна. Энэ хөтөлбөрт олс ашиглан аврах аврагч, хязгаарлагдмал орон зайн ажиллагааны аврагч, тээврийн хэрэгсэл болон машинаас хүн татаж гаргах ажиллагааны

аврагч, барилгын осол аваараас аврах ажиллагааны аврагч, усны гүнээс аврах ажиллагааны аврагч, гадаргын усны үерээс аврах аврагч зэрэг сэдвүүд байна. Эдгээр аврагчдын төрөл нь стандарт төрлүүдэд багтдаг бөгөөд шумбагч аврагч, далайн гүний ослоос аврах аврагч зэрэг олон төрөл байдаг ба мөн хязгаарлагдмал цөөн тооны мөсний аврагчид байна. Гэсэн хэдий боловч стандартад багтдаггүй аврагчийн төрөл байна энэ төрлүүд мөн аврагчийн сургалтын хөтөлбөрт ч багтдаггүй жишээ нь: тариалангийн талбайг хамгаалах, ан агнуураас зэрлэг болон ховордсон ан амьтдыг аврах. Бусад төрлийн аврагчид хөтөлбөрийн хүрээнд аврагчийн техникийн сургалтын хөтөлбөрт хамрагдана. Энэ хөтөлбөрт:

- 1 ба 2-р шатны - Хязгаарлагдмал орон зайд аврах ажиллагаа явуулах сургалт
- Агнуурын амьтад болон тариалангийн талбай устгагдахаас хамгаалах аврах ажиллагааны сургалт
- Аврах ажиллагаа явуулах техник хэрэгсэл
- Кансас мужид болж болзошгүй усны үерээс аврах ажиллагааны бэлтгэл
- Аврах систем 1
- Аврах систем 2
- Олс ашиглан аврах үйл ажиллагаа
- Олс ашиглан аврах үйл ажиллагааны үндсэн зарчим, техник
- Барилгын нурангиас аврах үйл ажиллагаа
- Барилгын нурангиас аврах үйл ажиллагааны техник
- Суваг шуудуунаас аврах -үйл ажиллагаа
- Тээврийн хэрэгслийг осол аваараас аврах ажиллагаа

Олс ашиглан аврах ажиллагааны техник 5 хоног 40 цагийн сургалт анхан шат болон гүнзгийрүүлсэн өндөр түвшний техникийн хөтөлбөрүүд үргэлжилнэ. Хязгаарлагдмал орон зайд аврах ажиллагааг гүйцэтгэх, үйлдвэрлэлийн ослын аврах ажиллагаа, уулархаг газар гарсан осол, гамшгаас аврах ажиллагаа явуулах ур чадварууд хамаарагдана. 1982 онд Олс ашиглан аврах ажиллагааг анхлан ашиглаж ирсэн бөгөөд энэхүү сургалтаараа хэрхэн олс ашиглан осол аваар болох үеэр аврах ажиллагааг амжилттай явуулах талаар мөн техник хэрэгслийн ашиглалт, хэрэглээ, хадгалалтын талаар судална. Мэргэжлийн аврагчийн сургалт туршлага он жил өнгөрөх тусам сургалтын чанар сайжирч, сургуулиуд улсын төсвөөс өгөх хөрөнгө мөнгө санхүүжилт өссөөр байна.

Ур чадварын сургалт

Тоног төхөөрөмжийн сонголт, хяналт шалгалт болон засвар үйлчилгээ, анхны тусламжийн хайрцаг ашиглалт, механик системийн давуу тал,

хамгаалалт, системийг бууруулах, олсоор буух, системийг нэмэгдүүлэх, дамжин өнгөрөх зангилаа, Системийн аюулгүй байдлын хүчин зүйлс, хог хаягдал тоос шороог цэвэрлэх, таслан авах, дамнуурга ашиглан нүүлгэн шилжүүлэх. Бодит байдал дээрх аврах ажиллагааг сургалтын аврах ажиллагааны хувилбарт заасан байдаг. Олон төрлийн сургалтын технологиудыг мэргэжлийн аврах, гал сөнөөх үйл ажиллагаатай уялдуулан эзэмшүүлдэг байна.

Сургалтын төлбөр

Бүртгүүлээд 45 хоногийн дотор төлбөрөө төлбөл 1075\$, бүртгүүлээд 45 хоногтоо багтаж төлбөрөө төлөөгүй нөхцөлд 1125\$ байна.

Оюутан сонсогчийн дээд талын хязгаар 16 хүнтэй хичээллэдэг байна.

Хосолсон ур чадвар

Олс ашиглан аврах техникч 1/2 ангийн аврах сургалтын зарчим, аврах олсны техник, галаас аврах, цамхагт ажиллаж байгаа хүмүүсийг олс хэрэглэж ур чадвараа ашиглан аврах бүрдэл бүхий техник, хязгаарлагдмал орчинд аврах ажиллагаа, эрэн хайх, аврах үйл ажиллагаа (USAR), уулархаг газарт гарсан ослоос аврах ажиллагаа, хот суурин газарт эрэн хайх, аврах үйл ажиллагаа явуулах (USAR), нисдэг тэрэг агаарын тээврийг ашиглан эрэн хайх аврах үйл ажиллагаа, завь ашиглан аврах ажиллагаа гүйцэтгэх, тактикийн маневр, аж үйлдвэрийн ослоос аврах.

Техникчийн түвшний 24 цагийн эрчимт онол практик хослуулсан сургалт аврагчийн гамшиг ослын үед нүүлгэн шилжүүлэлт хийх ур чадвар NEPA 1006 стандартын дагуу. Практикт яаралтай түргэн тусламжийг цаг алдалгүй мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэх.

Аврагчийн үйл ажиллагааны үндсэн гол зүйл бол аврагчийн аврах тоног төхөөрөмж юм. Эдгээр төхөөрөмжүүдийн хэрэглээ, ашиглалт техникийн үнэлгээ

бүрэн бүтэн байдлыг онол болон практикийн түвшинд судлах нь хамгийн чухал ач холбогдолтой байна.

1980-иад оны эхээр аврах анги, нэгтгэлийн сургалт тэдгээрийн хичээлийн хөтөлбөр анх үүсэн бий болжээ. Он жил өнгөрөх тусам аврах ажиллагаа, аврагчийн нарийн мэргэжил өргөжин тэлснээр барилга байгууламжийн, хүнд даацын авто тээврийн болон уул уурхай, түүнчлэн өндөр технологийн гээд олон ажиллагааг зохион байгуулах шаардлага урган гарсан.

Тэдний гол зорилго бол эрэн хайх аврах ажиллагааг яаралтай түргэн шуурхай хийж гүйцэтгэх.

Зааварлагчийн удирдсан практик сургалтыг хийж гүйцэтгэх тусам ур чадвар сайжирдаг байна.

Аюулгүй байдлыг хангах сургалтыг аврагчид илүү үр дүнтэй болгохын тулд мөн ажиллагааны ур чадвараа нэмэгдүүлэхэд сургалтын талбайд олон цагаар бэлтгэл сургуулилт хийх шаардлагатай. Бодит байдалд илүү ойр байхын тулд тухайн орчин нөхцөлийг амьд мэт бүрдүүлж өгөх нь суралцагчийн сэтгэл зүйд ч мөн эерэгээр нөлөөлж сургалтын чанарыг сайжруулна.

Тусламж үзүүлэх аврагчийн сургалтын курс

Сүүлийн жилүүдэд дэлхийн дулааралтай холбоотойгоор маш олон тооны осол байгалын гамшиг тохиолдог болж байгаа. Үүнтэй холбоотойгоор аврагч тэр дундаа шумбагч, завьтай аврагч гээд олон төрлийн шинэ сургалтын системүүд шинээр бий болсон байна.

Дүгнэлт

Олон улсын аврагч, гал сөнөөгч нар нь мэргэжлийн дагуу дипломын буюу түүнээс дээш боловсролтой байдаг байна. Энэ нь аврагч, гал сөнөөгч нарын мэдлэг, боловсролын түвшинг харуулж байгаа ба нөгөө талаасаа гамшиг ослын үед эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагааг илүү үр дүнтэй гүйцэтгэх баталгаа болж байгаа юм.

Байгууллагад ажиллаж буй хүмүүсийн ажлын гүйцэтгэлээс байгууллагын ажлын эцсийн үр дүн хамаардаг. Өндөр хурдацтай өөрчлөгдөж байгаа шинжлэх ухаан, техник, технологийн хөгжил дэвшил, өөрчлөлт зэрэгт зохицон ажиллахын тулд байгууллага ажиллагсдынхаа мэдлэг, чадвар, чадамжийг байнга тасралтгүй дээшлүүлж байх хэрэгцээ шаардлага урган гарч ирж байна.

Тиймээс байгууллагын шаардлагад нийцсэн боловсон хүчинтэй байх, тэрхүү боловсон хүчнийхээ мэдлэг мэргэжил, ур чадварыг нэмэгдүүлэх талаар системтэй үйл ажиллагаа явуулах зайлшгүй шаардлага бий болж байгаа билээ.

Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын сургалт явуулах эрх зүйн орчин, Аврах анги салбарт явагдаж буй сургалт, бэлтгэл, мэргэжлийн аврагч нарыг бэлтгэх, тэднийг давтан сургах, мэргэшүүлэх үйл ажиллагааны тогтолцоо, сургалтын агуулга, сургалт, дадлагын төвийн үйл ажиллагааг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Ашигласан материал

1. Burmaa N (2016) conference bookiet 8 shajing the future- organizational development in public administration.
2. М.Тэгшжаргал. Боловсрол судлал. УБ, 2010 он
3. ШУ-ны доктор, профессор О.Үржин Гамшгийн удирдлагын өөрчлөлт, шинэчлэл. Илтгэл, Үндэсний бага хурал. УБ. 2001 он
4. Я.Цэвэл. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, УБ. 2013 он
5. ОБЕГ,2012
6. С.Нарангэрэл “Монголын эрх зүйн англи, орос, латин хадмал эх толь бичиг”, УБ. 2015 он
7. ОБЕГ-ын даргын 2019 оны А/239 тушаал
8. Fire-related laws of korea 2016.
 1. “Эрэн хайх аврах ажиллагаа ОББС 0001:2018” стандарт
 2. Гамшгаас хамгаалах тухай хууль
салбарт гарч болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх болоод таслан зогсоох аврах үйл